

Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль болон Засгийн газрын 2017 оны 295, 104 дүгээр тогтоолуудыг үйл ажиллагаандаа удирдлага болгон их сургуулийн эрдэмтэд, судлаач багш нарын шинжлэх ухаанч үйл ажиллагааг үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд чиглүүлэх зорилгоор 2019 оны 04 дүгээр сарын 11-нд УХЭШХ-тэй, 2019.05.06-нд ХААИС-тай, 05.21-нд ШАУИС-тай тус тус санамж бичиг, гэрээ байгуулж, хамтын ажиллагааны төлөвлөгөөг батлан үйл ажиллагаа явуулж, биелэлтийг хүргүүлсэн. ШУТИС-ийн дэд захирал Т. Намнан ахалсан 9 хүний бүрэлдэхүүнтэй багийг Багануурт 2019.05.16-нд урьж Парк, Уурхайтай танилцуулж улмаар хамтран ажиллах гэрээ байгуулах ажлыг зохион байгуулав.

